Жилийн үйл ажиллагааны тайлан /маягт 1/

*Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.*

| | |
|---|---|
| *Тайлагнах хугацаа /Жишээ нь: 2022 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 6 дугаар сарын 30-ний өдөр/* | *2022 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр* |
| *Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар* | *"Монинжбар" ХК, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар 9010001062, үнэт цаасны код 25-МОНИНЖБАР , утас 311585, 91918822.* |
| *Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр* | *"Би Ди Сек ҮЦК" ХК* |
| *Бизнесийн үйл ажиллагааны салбар* | *Барилга дэд бүтэц, инженерийн шугам сүлжээ* |
| *Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг* | *15 869 233* |
| *Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр* | *Тайлан гаргасан: "Монинжбар" ХК-ийн нягтланг бодогч Д.Байгальмаа, хянасан: Захирал Г Нарантуяа* |

| | | | | |
|---|---|---|---|---|
| *1.* | *Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/* | | | |
| | *Санхүүгийн байдлын үзүүлэлт* | ***Үзүүлэлт*** | ***Эхний үлдэгдэл*** | ***Эцсийн үлдэгдэл*** |
| | | ***Хөрөнгө*** | | |
| | | *Эргэлтийн хөрөнгө* | *3,317,492,575.51* | *2,825,597,014.37* |
| | | *Эргэлтийн бус хөрөнгө* | *781,500,610.06* | *470,843,806.72* |
| | | ***Нийт хөрөнгө*** | ***4,098,993,185.57*** | ***3,296,440,821.09*** |
| | | ***Өр төлбөр ба эздийн өмч*** | | |
| | | *Богино хугацаат өр төлбөр* | *2,670,381,211.23* | *1,866,092,016.27* |
| | | *Эздийн өмч* | *1,428,611,974.34* | *1,430,348,804.82* |
| | | ***Нийт төлбөр ба эздийн өмч*** | ***4,098,993,185.57*** | ***3,296,440,821.09*** |
| | *Орлогын тайлан* | *Үзүүлэлт* | *Эхний үлдэгдэл* | *Эцсийн үлдэгдэл* |
| | | *Борлуулалтын орлого* | *1,216,279,117.51* | *7,728,076,071.81* |
| | | *Борлуулсан бүтээгдэхүүний өртөг* | *520,328,400.00* | *7,296,325,527.98* |
| | | *Нийт ашиг* | *695,950,717.51* | *431,750,543.83* |
| | | *Ерөнхий ба удирдлагын зардал* | *795,336262.41* | *429,820,732.19* |
| | | *Татвар төлөхийн өмнөх ашиг алдагдал* | *-99,385,544.90* | *1,929,811,64* |
| | | *Орлогын татварын зардал* | *00.00* | *192,981.16* |
| | | *Татварын дараахь ашиг алдагдал* | | ***1,736,830.48*** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | *Өмчийн өөрчлөлтийн тайлан* | *Үзүүлэлт* | *Эхний үлдэгдэл* | *Эцсийн үлдэгдэл* |
| | | *Хувьцааны дүн* | *1,586,923,300.00* | *1,586,923,300.00* |
| | | *Хуримтлагдсан ашиг алдагдал* | *-158,311,325.66* | *-156,574,495.18* |
| | | ***Нийт эздийн өмчийн дүн*** | ***1,428,611,974.34*** | ***1,430,348,804.82*** |
| | *Мөнгөн гүйлгээний тайлан* | *Үзүүлэлт* | *Эхний үлдэгдэл* | *Эцсийн үлдэгдэл* |
| | | *Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйгээний дүн* | *571,248,825.00* | *-3,778,113,710.29* |
| | | *Хөрөнгө оруулалтын үйл ажил-лагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн* | *00.00* | *10,300,000.00* |
| | | *Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн* | *-563,165,309.01* | *3,958,684,067.65* |
| | | ***Бүх цэвэр мөнгөн гүйлгээ*** | ***8,083,515.99*** | ***170,270,357.36*** |
| | | *Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл* | *11,702,000.87* | *19,785,516.86* |
| | | ***Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл*** | ***19,785,516.86*** | ***190,055,874.22*** |

| | |
|---|---|
| ***1.2*** | *Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт* |
| | |

МОНИНЖБАР ХК-ИЙН УДИРДЛАГАД

**NIYAMAZON AUDIT LLC**
#408, Building of Trade Union Federation,
Choimbol street, Chingeltei district,
Ulaanbaatar 15172, Mongolia
Tel: (976)70145906, (976) 91005906
E-mail:audit@nmz.mn

_______________№_______________

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

### Дүгнэлт

Бид Монинжбар ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусвар болсон орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр хавсаргасан санхүүгийн тайлангууд нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Монинжбар ХК-ийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусвар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (СТОУС)-ын дагуу үнэн, бодитой илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэлээ. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол Улсын Аудитын тухай хуулийн шаардлагын дагуу компаниас хараат бус байж бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болсон гэдэгт бид итгэлтэй байна.

### Санхүүгийн тайланд хүлээх удирдлагын үүрэг хариуцлага

Санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу залилан болон алдаанаас улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийллээс ангид бэлтгэхэд шаардлагатай гэж тодорхойлсон дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх нь удирдлагын үүрэг хариуцлага юм. Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага нь компанийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх ба нөлөөлөх асуудлыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг баримтлах үүрэгтэй.

### Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу тайлагналаас санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Хэдийгээр үндэслэлтэй баталгаа нь өндөр түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг олж илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй. Буруу илэрхийлэл нь залилан болон алдааны улмаас үүсч болох ба дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцно.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн ул итгэх байр сууринаас хандаж, мэргэжлийн итгэл үнэмшил бүхий үнэлэлтийг хийдэг. Бид мөн:

- Залилан болон алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, тохирох аудитын горимыг боловсруулж, дүгнэлтийн үндэслэл болохуйц нотолгоог олж авдаг. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэгтэй холбоотой үүсдэг тул алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын зүгээс мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал болон хийсэн тооцоолуудын үндэслэлтэй байдал, холбогдох тодруулгуудыг үнэлдэг.
- Компанийн үйл ажиллагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Тодруулгуудыг оролцуулан санхүүгийн тайлангийн ерөнхий агуулга болон бүтцийг бүхэлд нь үнэлдэг ба ач холбогдол бүхий ажил гүйлгээ, үйл явдлуудыг санхүүгийн тайланд үнэн зөв тодруулах шаардлагыг хангахуйц байдлаар илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид засаглал хариуцсан эрх бүхий этгээдэд аудитын үйл ажиллагааны төлөвлөсөн цар хүрээ, аудит гүйцэтгэх цаг хугацаа болон аудитын явцад олж илрүүлсэн томоохон асуудлуудын талаар мэдээлдэг бөгөөд үүнд дотоод хяналтын дутагдалтай талууд мөн багтдаг.

**Тайлангийн хэрэглээ**

Энэхүү тайланг талуудын хооронд байгуулсан аудитын ажлын гэрээт захидалд заасны дагуу компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

НИЯМАЗОН АУДИТ ХХК
УЛААНБААТАР ХОТ

З.Цэнз
Захирал
Ниямазон аудит ХХК

Улаанбаатар хот, Монгол Улс
2023 оны 02 дугаар сарын 09

| | |
|---|---|
| 1.3 | *Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/* |

**NIYAMAZON AUDIT LLC**

#408, Building of Trade Union Federation,
Choimbol street, Chingeltei district,
Ulaanbaatar 15172, Mongolia
Tel: (976) 70145906, 91005906
E-mail: audit@nmz.mn

2023.01.12

МОНИНЖБАР ХК-ИЙН
УДИРДЛАГАД

**Аудитын гэрээт ажлын захидал**

Биднээс Монинжбар ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх байгууллагын санхүүгийн байдлын тайлан болон жилийн эцсээр тасалбар болсон орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээний тайланд аудит хийх хүсэлтийг тавьсан билээ. Бид тус компанийн санхүүгийн тайланд аудит хийхийг зөвшөөрч байгаа бөгөөд энэхүү захидлаараа гэрээт ажлын талаар өөрсдийн ойлголтоо илэрхийлж байна.

Санхүүгийн тайлангууд бүхэлдээ залилан, алдааны улмаас материаллаг буруу илэрхийлэлгүй эсэх талаар үндэслэл бүхий баталгаа олж авах, энэ тухай өөрсдийн дүгнэлтийг тусгасан хараат бус аудиторын тайланг бэлтгэн гаргах нь бидний аудитын зорилго юм. Үндэслэл бүхий баталгаа гэдэг нь өндөр түвшний баталгаа боловч материаллаг хэмжээний бүх алдааг АОУС-ын дагуу гүйцэтгэсэн аудитын ажлаар илрүүлнэ гэсэн баталгаа өгч байгаа явдал биш юм. Алдаатай буруу илэрхийлэл нь залилан, алдааны улмаас үүсэх бөгөөд санхүүгийн тайлангийн мэдээлэлд үндэслэн хэрэглэгчийн гаргаж буй эдийн засгийн шийдвэрт нөлөөлнө гэж таамаглаж байгаа нөхцөлд дангаараа эсвэл нийлээд байдлаар материаллаг чанарыг хадгална.

Бид аудитаа Аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэнэ. Эдгээр стандартууд нь санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй эсэх талаар зохистой нотолгоо олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэх ёс зүйн шаардлагуудыг мөрдөж ажиллахыг шаарддаг. Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажил багтана. Аудит нь мөн байгууллагын удирдлагын сонгон хэрэглэж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой эсэх, нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудын бодитой эсэхийг үнэлэх ажлууд багтана.

Аудитын тестийн мөн чанар болон нягтлан бодох бүртгэл болон дотоод хяналтын систем дэх уламжлалт хязгаарлалтуудаас шалтгаалан зайлшгүй боломжгүй эрсдлүүдтэй холбоотойгоор зарим материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байж болох юм. Бид нягтлан бодох бүртгэл болон бидний анхааралд өртсөн дотоод хяналтын системд оршин байгаа материаллаг сул талуудыг харуулсан тусгай захидлыг бэлтгэж хүргүүлэх болно.

Санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэх нь компанийн удирдлагын хариуцлага бөгөөд зохистой нягтлан бодох бүртгэл болон дотоод хяналтын системийг бий болгох, бүртгэлийн бодлогыг сонгох ба хэрэглэх, компанийн хөрөнгийг хадгалж хамгаалах зэрэг багтана. Бидний аудитыг хэрэгжүүлэх явцад удирдлагыг аудиттай холбоотой бичгэн баталгааг гаргахыг хүсэх болно.

Аудитын явцад бүртгэл, баримт материал болон бусад мэдээллээр бүрэн хангана гэдэгт итгэлтэй байна. Бидний ажлын хөлс нь ажлын явцад нэхэмжлэгдэх бөгөөд гэрээт ажлыг гүйцэтгэхтэй холбоотой аудитын ажилтнуудын цалин хөлс болон бусад холбогдох зардлуудаас бүрдэнэ. Хүн цагаар тооцсон ажлын хөлс нь үр чадвар, туршлага дээр үндэслэгдсэн аудитын ажилд оролцох хүн бүрийн хувьд өөр өөрөөр тооцогдсон.
Талуудын хүлээх үүрэг хариуцлага болон бидний гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитын нөхцлийн тухай ойлгож хүлээн зөвшөөрч байгаа бол энэхүү захидалд гарын үсэг зурж бидэнд буцаан илгээнэ үү.

З.[illegible]
Захирал

Танилцаж хүлээн зөвшөөрсөн:
Монинжбар ХК
Гүйцэтгэх захирал
Б.Наранчува

| | | | |
|---|---|---|---|
| 2. | *Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл* | | |
| 2.1 | *Үйл ажиллагааны үр дүн санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд* | *Нийт ашгийн хувь* | *0.06%* |
| | | *Үйл ажиллагааны ашгийн хувь* | *0.00%* |
| | | *Цэвэр ашгийн хувь* | *0.00%* |
| | | *Өөрийн хөрөнгийн өгөөж* | *0.12%* |

| | | |
|---|---|---|
| *2.2* | *Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц боломжийн үзүүлэлт* | *Эргэлтийн харьцаа 1.51*<br>*Түргэн хөрвөх чадварын харьцаа 0.59*<br>*Өр болон өөрийн хөрөнгийн харьцаа 0.57* |
| *2.3* | *Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл* | *Цар тахал, хил гаалийн үйл ажиллагаа болон Украйны дайнтай холбоотой гадаад орчинд түүхий эд материалын үнэ өсөх, инфляци нэмэгдэх, төгрөгийн ханш суларч, гадаад валютын ханш өсөх эрсдлийн нөлөөлөл их байна.* |
| *2.5* | *Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлтийн болон зээлийн барьцаа баталгааны талаарх мэдээлэл* | *2022 оны 12-р сарын 25-нд ХААН банкнаас 500.0 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийн зээлийг 12сарын хугацаатай авсан. Эргэл төлөх хугацаа болоогүй байна.* |
| *3.* | *Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/* | |
| | *Хийгдээгүй.* | |
| *4.* | *Цалин урамшуулалын мэдээлэл* | |
| | *Инженер техникийн ажилтан, ажилчид нь барилгын салбарын жишгээр үнэлэгддэг.. 2022 онд урамшуулал олгоогүй.* | |
| *5.* | *Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл* | |
| | ***Хувьцаа эзэмшигчдийн хурал.***<br>*"Монинжбар" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2022 оны 4-р сарын 30-ны өдөр Улаанбаатар хот Хан-Уул дүүргийн 18-р хороо LS плаза 902 тоот танхимд болж дараахь шийдвэрүүдийг гаргав. Үүнд:*<br>*1. 2021 оны үйл ажиллагаа хангалттай, санхүүгийн тайлангийн талаар хэлэлцэж хангалтгүй гэж дүгнэсэн.*<br>*2. 2022 оны ажлын төлөвлөгөө, төслийг батлав.* | |
| *6.* | *Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл* | |
| | *Төрийн худалдан авалтаар ажил гүйцэтгэдэг тул хугацаандаа гүйцэтгэлийн санхүүжилт орж ирдэггүй, бусад хөндлөнгийн шалтгаанаар гэрээт ажлын хугацаа сунаж байгаа тул жилээс жилд компанийн алдагдал өсч байна. Энэ нь тогтвортой ажлын байраа алдах, үндсэн үйл ажиллагаанд маш их хохирол учруулж байна.* | |
| *7.* | *Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/* | |
| | *Нийт хувьцаа эзэмшигч 283*<br>*"Би Ди Сек ҮЦК" ХК 1,008,085 ширхэг буюу 6.35%*<br>*Баянжаргалын Цогтгэрэл 3,548,345 ширхэг буюу 22.36%*<br>*Цогтгэрэлийн Оргилболд 912,000 ширхэг буюу 5.75%*<br>*Цогтгэрэлийн Чингүүнболд 1,824,000 ширэхг буюу 11.49%*<br>*Батаагийн Нарантуяа 4,231,920 ширхэг буюу 26.67%* | |
| *8.* | *Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дараах хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл* | |
| | *Хувьцаа гаргаагүй.* | |
| *9.* | *Ногдол ашгийн мэдээлэл* | |
| | *Ноогдол ашиг тараах боломжгүй* | |

| | |
|---|---|
| ***10.*** | *Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл* |
| | 1. *Нийт ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамруулсан.*<br>2. *Компанид он удаан жил үр бүтээлтэй ажилласан 3 ажилтныг төрийн дээд одон медалиар шагнуулсан.*<br>3. *Баянгол дүүргийн 20-р хороотой хамтран олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан 50 хүүхдэд бэлэг бэлдэн өгсөн.*<br>4. ***Тэрбум мод*** *үндэсний рхөдөлгөөнийг дэмжиж Баянгол паркид шар хуайс, хайлаас, гацуур зэрэг 100 ширхэг мод тарьсан.* |

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

| | |
|---|---|
| Овог, нэр: Б.Нарантуяа<br><br>Албан тушаал: "Мonинжбар" ХК-ийн гүйцэтгэх захирал<br><br>Гарын үсэг: ..........................<br><br>*(Тамга/тэмдэг)* | |

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Д.Байгальмаа

Албан тушаал: Нягтлан бодогч

Гарын үсэг: ..............................